

# ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

## /БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ/

### **Ерөнхий зүйл**

Боловсролын ерөнхий хуулийн төслийг хэрэгжүүлэхэд иргэн, хуулийн этгээд буюу аж ахуйн нэгж байгууллага, төрийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой энэхүү төсөлд тусгасан үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан гаргах зардлыг тооцож, түүний үндсэн дээр эдгээрт ногдох зардал, үйл ажиллагааны ачааллыг багасгаж, зохицуулалтын боломжит хувилбарыг боловсруулахад энэхүү зардлын тайлангийн гол зорилго нь оршино.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоог Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хуулийн 18.1 дэх хэсэгт тусгаснаар Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-д дурдсаны дагуу хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй гарах зардал, нөлөөллийг эрх зүйн зохицуулалтад хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын зардал тус бүрээр тооцон боловсруулсан.

### **1. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫГ ТООЦОО**

#### **Төрийн захиргааны байгууллагын чиг, үүргийг тодорхойлох**

Аргачлалын 4.1-д заасны дагуу Боловсролын ерөнхий хуулийн төсөлд төрийн захиргааны байгууллагын гүйцэтгэх үүрэг /ажил үйлчилгээ/, тухайн үүргийг ямар ямар байгууллага гүйцэтгэх талаар тогтоосныг хүснэгт 1-р харуулав.

Хүснэгт 1 [Error! Not a valid link.](#)

Дээрх хүснэгтээс харахад Боловсролын ерөнхий хуулийн төсөлд тусгагдсан төрийн захиргааны үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүргийг дараах байгууллагууд гүйцэтгэхээр байна.

1. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
2. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага
3. Аймаг, нийслэлийн Боловсролын газар
4. Дүүргийн Боловсролын хэлтэс

Боловсролын ерөнхий хуулийн хэрэгжилттэй холбогдон гарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын зардлыг одоогийн мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн зарим зүйл, заалтад нэмж туссан болон өөрчлөлт орсон зүйл заалт тус бүрээр тооцон боловсруулсан.

Өөрөөр хэлбэл хуулийн төсөлд одоогийн мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн төсөлд хэвээр туссан, иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад нэмэлтээр зардлын нөлөөлөл үзүүлэхгүй зүйл заалтыг одоогийн батлагдсан орон тоо, төсөв, зардалд нөлөөлөхгүй гэж үзсэн. Харин төрийн байгууллагад нэмэлт зардал шаардагдах гүйцэтгэх чиг, үүргийн зүйл, заалтын зардлыг тусгасан.

Тус хуулийн төсөлд одоогийн мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн зүйл заалтад өөрчлөлт орсон болон нэмж туссан, төрийн байгууллагын зардалд нөлөөлөх зүйл заалтыг дараах хүснэгтээр харуулав.

/Хүснэгт 2/

Боловсролын ерөнхий хуулийн төслийн төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлэх холбогдох зохицуулалт	Чиг үүргийг хэрэгжүүлэхэд нөлөөлөх зүйл заалт	Чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллага	
Боловсролын сургалтын байгууллагын удирдах ажилтан, багшийг нэгдсэн бодлого, тодорхой чиглэлээр бэлтгэх, давтан сургах, тэдний нийгмийн баталгааг хангах асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, энэ талаар гарсан шийдвэрийн биелэлтийг хангах;	Сургуулийн өмнөх, бага, дунд боловсролын болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага нь тухайн байгууллагын нийт хувьсах зардлын хоёроос доошгүй хувийг багш хөгжлийн төвийн үйл ажиллагаанд зарцуулна.	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Боловсрол сургалтын байгууллага	
Боловсролын хөтөлбөр, норм, нормативын хэрэгжилт, боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийн чанарт үнэлгээ хийх, дүгнэлт гаргах, хүүхдийн хөгжлийн ахиц дэвшлийг дэмжих, баталгаажуулах;	Хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх сонгон хичээл, дугуйлан хичээллүүлэх, төрөлжсөн хичээлийн улсын олимпиад зохион байгуулах, олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн шинжлэх ухааны олимпиадад ерөнхий боловсролын сургуулийн суралцагч гадаад улс оронд оролцохтой холбогдох зардлын тодорхой хувийг улсын төсвөөс санхүүжүүлнэ.	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Боловсрол сургалтын байгууллага	
Тэргүүлэх болон нэн шаардлагатай мэргэжлийн жагсаалтыг 3 жил тутам шинэчлэн боловсруулах;	Тэргүүлэх болон нэн шаардлагатай мэргэжлээр суралцагчийн сургалтын төлбөрийн тодорхой хувийг төр хариуцна.		
Боловсролын удирдлагын тогтолцоо нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон <b>боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага</b> , нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, аймаг,	Боловсролын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага	
	Сурах бичиг зохиох, хэвлэх, ханган нийлүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах, сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж, урвалж бодисоор хангах, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах;		
	Багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах;		

нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэс, боловсролын байгууллагын удирдлагаас бүрдэнэ.	Аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтсийг мэргэжил, арга зүйн удирдлага, зохицуулалтаар хангах;
	Бүх шатны боловсролын сургалтын чанарт үнэлгээ, судалгаа хийх, их, дээд сургууль, коллежид элсэгчдийн элсэлтийн шалгалтыг үндэсний түвшинд хариуцан зохион байгуулах;
	Боловсролын салбарын мэдээллийн технологийн хэрэгжүүлэлт, хөгжүүлэлт, мэдээллийн систем, сан, нэгдсэн сүлжээ болон тэдгээрийн дэд бүтцийн хяналт, аюулгүй байдлын хэрэгжилтийг хангах
	Боловсролын болон сургалтын баримт бичгийг хэвлүүлэх, түгээх, олгох ажлыг зохион байгуулах;
	Улсын олимпиад зохион байгуулах журам, ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори байгуулах, ашиглах журам баталж мөрдүүлэх;
	Гадаад улс, олон улсын төрөлжсөн бусад байгууллагатай боловсролын салбарын чиглэлээр байгуулсан олон улсын гэрээний хэрэгжилтийг зохион байгуулах;
	Боловсролын салбарын үйл ажиллагааны талаарх мэдээ, тайланг улсын хэмжээнд нэгтгэн гаргах, хуульд заасны дагуу мэдээлэх;
	Мэргэжлийн болон дээд боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журмыг батлан хэрэгжилтийг хангах;
	Гамшгийн улмаас хичээл, сургалтын үйл ажиллагааг түр зогсоох, хэлбэр өөрчлөх тохиолдолд сургалтын тасралтгүй байдлыг хангах хариу арга хэмжээ авах нэгдсэн зохицуулалт хийх;
Насан туршийн боловсрол олгох үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулах;	

## **Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зардлын тооцоо**

### **Хүний нөөцийн зардлын тооцоо**

Хуулийн төслийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Боловсролын удирдлагын тогтолцоо нь Засгийн газар, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэс, боловсролын байгууллагын удирдлагаас тус тус бүрдэнэ” гэж туссан.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ыг 1 дүгээр хавсралтын 4-т Боловсролын засаглал, удирдлагын тогтолцоог тодорхой болгож, тасралтгүй сайжрах хариуцлагын тогтолцоог бүрдүүлсэн байна гэж заасны дагуу хуулийн төсөлд байгууллагын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орж хуулийн төсөлд тусгагдсан чиг үүрэг бүхий байгууллага нь Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага юм.

Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Боловсролын газар, дүүргийн Боловсролын хэлтсийн чиг үүрэг

одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн дагуу зүйл заалт хэвээр үргэлжлэн явагдах бөгөөд төрийн байгууллагад нэмэлтээр зардал шаардагдахгүй бөгөөд батлагдсан орон тоо, төсвөөр ажиллахаар тооцсон.

Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа 6 байгууллагыг нэгтгэн Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг байгуулахаар хуулийн төсөлд тусгасан. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад харьяалагддаг 6 байгууллагын 2021 онд батлагдсан төсвийг хүснэгтээр харуулав. /Хүснэгт 3/

/сая төгрөгөөр/

Харьяа байгууллага	Батлагдсан орон тоо	Батлагдсан төсөв
Багшийн мэргэжил дээшлүүлэх институт	70	1,345.69
Боловсролын үнэлгээний төв	24	1,201.02
Насан туршийн боловсролын үндэсний төв	13	227.62
Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл	20	150.00
Боловсролын зээлийн сан	23	49,708.39
Боловсролын мэдээллийн технологийн төв	43	5,648.50
<b>Дүн</b>	<b>193</b>	<b>58,281.2</b>

Аргачлалын 4.4.3.2 үргэлжилсэн шинжтэй, тасралтгүй хийгдэх ажил, үйлчилгээг тогтоох боломжгүй тохиолдлын тоонд хамааруулна. Тухайлбал, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг хэдэн жилээр үргэлжлүүлэн хэрэгжүүлж болох бөгөөд энэ нөхцөлд шаардагдах хүний нөөцийг шууд баримжаалж тооцно гэж заасны дагуу Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг одоогийн ажиллаж буй харьяа 6 байгууллагын нэгтгэхэд орон тоог нэмэгдүүлэхгүй байхаар тооцов.

/Хүснэгт 4/

Чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллага	Чиг үүргийг хэрэгжүүлэхэд нөлөөлөх зүйл заалт	Зарцуулах хугацаа /минут/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ
Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага	Боловсролын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;	Аргачлалын 4.4.2.зарцуулах хугацааг тодорхойлохдоо бусад төрийн байгууллагад адил төстэй үйлчилгээ байгаа эсэхийг судалж, холбогдох мэргэжилтнүүдийн саналыг авах бөгөөд тэдгээрийн гүйцэтгэсэн ажил, үйлчилгээгээр баримжаалж тогтооно. Мөн аргачлалын 4.4.5.2.тохиолдлын тоог тогтоох боломжгүй үед хүний нөөцийн хэрэгцээг	193	
	Сурах бичиг зохиох, хэвлэх, ханган нийлүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах, сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж, урвалж бодисоор хангах, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах;			
	Багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах;			
	Аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтсийг мэргэжил, арга зүйн удирдлага, зохицуулалтаар хангах;			
	Бүх шатны боловсролын сургалтын чанарт үнэлгээ, судалгаа хийх, их, дээд сургууль, коллежид элсэгчдийн элсэлтийн шалгалтыг үндэсний түвшинд хариуцан зохион байгуулах;			

Боловсролын салбарын мэдээллийн технологийн хэрэгжүүлэлт, хөгжүүлэлт, мэдээллийн систем, сан, нэгдсэн сүлжээ болон тэдгээрийн дэд бүтцийн хяналт, аюулгүй байдлын хэрэгжилтийг хангах	баримжаалан тооцно гэсний дагуу одоогийн батлагдсан орон тоог нэмэгдүүлэхгүй байхаар тооцов.
Боловсролын болон сургалтын баримт бичгийг хэвлүүлэх, түгээх, олгох ажлыг зохион байгуулах;	
Улсын олимпиад зохион байгуулах журам, ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори байгуулах, ашиглах журам баталж мөрдүүлэх;	
Гадаад улс, олон улсын төрөлжсөн бусад байгууллагатай боловсролын салбарын чиглэлээр байгуулсан олон улсын гэрээний хэрэгжилтийг зохион байгуулах;	
Боловсролын салбарын үйл ажиллагааны талаарх мэдээ, тайланг улсын хэмжээнд нэгтгэн гаргах, хуульд заасны дагуу мэдээлэх;	
Мэргэжлийн болон дээд боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журмыг батлан хэрэгжилтийг хангах;	
Гамшгийн улмаас хичээл, сургалтын үйл ажиллагааг түр зогсоох, хэлбэр өөрчлөх тохиолдолд сургалтын тасралтгүй байдлыг хангах хариу арга хэмжээ авах нэгдсэн зохицуулалт хийх;	
Насан туршийн боловсрол олгох үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулах;	

Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь 8 газар, 13 хэлтэс 193 орон тоотойгоор ажиллахаар тооцсон.

/Хүснэгт 5/

Бүтэц	Албан тушаал
<b>Боловсролын ерөнхий газар</b>	<b>192</b>
<b>Удирдлага</b>	<b>3</b>
Удирдлага	3
<b>Удирдлага менежментийн газар</b>	<b>23</b>
Боловсролын инновац, технологийн хэлтэс	9
Боловсролын статистик, мэдээллийн хэлтэс	4
Боловсролын удирдлага, менежментийн хэлтэс	6
Боловсролын хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	4
<b>Багшийн хөгжил, арга зүйн газар</b>	<b>40</b>
Багшийн хөгжлийн хэлтэс	16
Сургалтын арга зүйн хэлтэс	24
<b>Боловсролын чанарын баталгаажуулалтын газар</b>	<b>35</b>
Боловсролын чанарын баталгаажуулалтын газар	35
<b>Захиргаа, хүний нөөцийн газар</b>	<b>35</b>
Захиргаа, хүний нөөцийн газар	35
<b>Насан туршийн суралцахуйн газар</b>	<b>8</b>
Насан туршийн суралцахуйн газар	8
<b>Суралцагчийн хөгжил, хамгааллын газар</b>	<b>19</b>
Оюутны хөгжлийн хэлтэс	1
Суралцагчийн хоол үйлдвэрлэлийн хэлтэс	4
Сургалтын орчин, аюулгүй байдлын хэлтэс	10

Тэгш хамран сургах боловсролын хэлтэс	2
Үндэсний цөөнх, хилийн чанад дахь хүүхдийн боловсролын хэлтэс	2
<b>Сургалтын хөтөлбөрийн хөгжлийн газар</b>	<b>16</b>
Боловсролын үнэлгээ, хөгжүүлэлтийн хэлтэс	1
Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн хэлтэс	15
<b>Төсөв, санхүү, хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн газар</b>	<b>14</b>
Төсөв, санхүү, хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн газар	14
<b>Grand Total</b>	<b>193</b>


Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага

Боловсролын чанарын баталгаажуулалт,

Боловсролын хөгжлийн бодлого, судалгааны



№	Нэгж	Ажил үйлчилгээ	Орон тоо	Цалингийн зардал	Хүний нөөцийн нийт зардал /төг/
1	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага	Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагыг байгуулах	193	16,847,391	3,251,546,400
НИЙТ			193	16,847,391	3,251,546,400

Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь 193 орон тоотой ажиллахад жилд 3.2 тэрбум төгрөгийн зардал гарах бөгөөд тус зардал нь 6 байгууллагын 2021 оны цалингийн зардалд батлагдсан бөгөөд төсөвт нэмж зардал шаардагдахгүй.

### ЗАРДЛЫН АНГИЛАЛ

### ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА

### НИЙТ ЗАРДАЛ

<b>ХҮНИЙ НӨӨЦИЙН ЗАРДАЛ</b>	+	<b>3,251,546,400</b>	=	<b>3,251,546,400</b>
-----------------------------	---	----------------------	---	----------------------

### Материаллаг зардлын тооцоо

Зардлын нэрс	Тоо хэмжээ	Нэгж зардал	Нийт үнэ
Гэрэл, цахилгаан	193	618,851	119,438,300
Түлш, халаалт	193	167,775	32,380,600
Цэвэр, бохир ус	193	46,547	8,983,600
Байрны түрээс	193	497,668	96,050,000
Бичиг хэрэг	193	104,898	20,245,400
Тээвэр, шатахуун	193	79,134	15,272,900
Шуудан, холбоо, интернэтийн телбэр	193	112,004	21,616,700
Ном, хэвлэл	193	1,701	328,200
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	193	8,168	1,576,500
Бага інэтэй, тiргэн элэгдэх, ахуйн эд зийлс	193	49,936	9,637,700
Эд хогшил, урсгал засварын зардал	193	19,635	3,789,600
Нормативт зардал	193	11,041	2,131,000
Томилолт, зочны зардал	193	119,692	23,100,600
Бусдаар гийцэтгiлсэн ажил, iйлчилгээний телбэр, хураамж	193	24,486,607	4,725,915,200
Бараа iйлчилгээний бусад зардал	193	5,127,770	989,659,700
Эргэж телегдэх зээл	193	175,054,770	33,785,570,600
Бусад урсгал шилжiiлэг	193	78,621,669	15,173,982,100
<b>Дүн</b>			<b>55,029,678,700</b>

Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын материаллаг зардлын тооцоог төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбогдон гарах зардлыг тооцсон бөгөөд 2021 онд батлагдсан харьяа 6 байгууллагын батлагдсан төсөвт үндэслэн тооцсон.

Хуулийн төслийг хэрэгжүүлэх Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад үүсэх нийт зардлыг дараах байдлаар тооцоолон гаргалаа.

### Зардлын нэгтгэл

ЗАРДЛЫН АНГИЛАЛ		ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА		НИЙТ ЗАРДАЛ
ХҮНИЙ НӨӨЦИЙН ЗАРДАЛ	+	3,251,546,400	=	3,251,546,400
	+			+
МАТЕРИАЛЛАГ ЗАРДАЛ	+	55,029,678,700	=	55,029,678,700
	=			=
НИЙТ ЗАРДАЛ		58,281,225,100	=	58,281,225,100

### Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах

Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад харьяалагддаг 6 байгууллагын нэгтгэн Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болгон бүтэц зохион байгуулалтыг өөрчлөхөд 193 орон тоотойгоор нийт 58.3 тэрбум төгрөгийн зардал гарахаар тооцсон бөгөөд нэмж улсын төсөвт зардал шаардагдахгүй байна.

### Боловсролын сургалтын байгууллагад үүсэх зардлын тооцоо

#### Төрийн байгууллагын зардлын тооцоо

Хуулийн төсөлд “Тэргүүлэх, нэн шаардлагатай мэргэжлээр суралцагчид сургалтын төлбөрийн тэтгэлэг, зээл олгоно” гэж заасан.

Боловсролын зээлийн сангаар дамжуулан оюутнуудын сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламжид Засгийн газраас баталсан журмын дагуу дараах зардлыг жил бүр улсын төсөвт баталж байна.

/тэрбум төгрөг/

Төрөл	Суралцагчийн тоо	2019 оны батлагдсан төсөв	Суралцагчийн тоо	2020 оны батлагдсан төсөв
Тэтгэмж	8161	19.7	5882	9.8
Зээл	18935	54.8	4890	31.9

Монгол Улсад шаардлагатай тэргүүлэх болон нэн шаардлагатай мэргэжлээр нэмж 6759 оюутныг Засгийн газрын 2018 оны 46 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан журмын дагуу зээлийг олгоход улсын төсөвт 10.1 тэрбум төгрөг шаардагдана.



№	Нэгж	Ажил үйлчилгээ	Тохиолдлын тоо	Олимпиадад оролцох давтамж	Сургалтын тэтгэлэг	Нийт зардал /төг/
1	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага	Тэргүүлэх болон нэн шаардлагатай мэргэжлээр суралцагчийн сургалтын төлбөрийн тодорхой хувийг төр хариуцна	6759	1	1,500,000	10,138,500,000
<b>НИЙТ</b>			<b>6,759</b>	<b>1</b>		<b>10,138,500,000</b>

Хуулийн төсөлд “Хөдөлмөрийн онцлогийг харгалзан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн захирал, эрхлэгч болон бусад ажилтанд ажлын 15, багш, туслах багш, дотуур байрын багш, нийгмийн ажилтан, арга зүйч, сургалтын менежерт ажлын 33 өдрийн нэмэгдэл амралт тус тус олгоно” гэж туссан.

Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.2-т “багш, ажиллагчдын ээлжийн үндсэн амралтын хугацааг Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулна. Хөдөлмөрийн онцлогийг харгалзан багшид ажлын 33, захирал, эрхлэгч, орлогч захирал, хичээлийн эрхлэгч /сургалтын менежер/, хичээлийн зохицуулагч, нийгмийн ажилтан, арга зүйч, дадлагын болон байрны багш, цэцэрлэгийн туслах багшид ажлын 15 өдрийн нэмэгдэл амралт тус тус олгоно” гэж заасан. Хуулийн төслийн “13 дугаар зүйлийн 13.3.3.хөдөлмөрийн онцлогийг харгалзан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн захирал, эрхлэгч болон бусад ажилтанд ажлын 15, багш, туслах багш, дотуур байрын багш, нийгмийн ажилтан, арга зүйч, сургалтын менежерт ажлын 33 өдрийн нэмэгдэл амралт тус тус олгоно” гэж туссанаар боловсролын байгууллагын багш, ажилчдын ээлжийн амралтын хоногт дараах өөрчлөлт гарахаар байна. Өөрчлөлтийг доорх хүснэгтээр харуулав.

## Хүснэгт



БОЛОВСРОЛ,  
ШИЖИЛЭХ УХААНЫ ЯАМ

### ЭЭЛЖИЙН АМРАЛТЫН ХОНОГ



Хөдөлмөрийн онцлогийг харгалзан сургууль, цэцэрлэгийн багш, ажилчдын нэмэгдэл амралтыг тооцоход төсөвт нийт 17.6 тэрбум төгрөг шаардагдахаар байна.

Д/д	Байгууллагын төрөл	Ээлжийн амралтын мөнгө		
		Одоогийн мөрдөж байгаа хуулийн заалтаар тооцсон	Хуулийн төсөлд туссан заалтаар тооцсон	Шаардагдах төсөв
1	Ерөнхий боловсролын сургууль	72,092,983,914	80,309,317,265	8,216,333,351
2	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага	40,112,491,413	49,540,678,032	9,428,186,619
3	Дүн	112,205,475,327	129,849,995,297	17,644,519,969

Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн төсөвт шаардагдах зардлын тооцоолол.

№	Нэгж	Ажил үйлчилгээ	Тохиолдлын тоо	Давтамж	Нийт зардал /төг/
1	Боловсрол сургалтын байгууллага /сургууль/	хөдөлмөрийн онцлогийг харгалзан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн захирал, эрхлэгч болон бусад ажилтанд ажлын 15, багш, туслах багш, дотуур байрын багш, нийгмийн ажилтан, арга зүйч, сургалтын менежерт ажлын 33 өдрийн нэмэгдэл амралт тус тус олгоно	52,025	1	8,216,333,350
	Боловсрол сургалтын байгууллага /цэцэрлэг/		27,652	1	9,428,186,619
<b>НИЙТ</b>			<b>6,759</b>	<b>1</b>	<b>17,644,519,969</b>

Хуулийн төслийн 43 дугаар зүйлийн 43.8-д “Төрөлжсөн хичээлийн улсын олимпиад зохион байгуулах, ерөнхий боловсролын сургуулийн суралцагч олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн шинжлэх ухааны олимпиадад оролцох болон төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх дугуйлангийн зардлын тодорхой хувийг улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж туссан.

Улсын төсвөөс сонгон секц, дугуйлан хичээллүүлэх зардлыг санхүүжүүлдэггүй тул цаашид санхүүгийн нөлөөлөл үүснэ. Төрөлжсөн хичээлийн олимпиадыг улсын хэмжээнд зохион байгуулдаг тул нэмэлт зардал үүсэхгүй. Олон улсын шинжлэх ухааны олимпиадад оролцуулах багийг улсын төсвөөс санхүүжүүлдэггүй тул нэмэлт санхүүгийн нөлөөлөл үүснэ.

Сургууль, цэцэрлэгийн суралцагчдад долоо хоногт 3-5 төрлөөр 2 цагийн дугуйлан, секц хичээллүүлэхэд багш нарын цалингийн зардал 91.5 тэрбум төгрөг шаардлагатай. Хичээлийн хөтөлбөрийн цагийн тооцоололд бусад хичээлийг орлуулсан тохиолдолд ямар нэг үр дагавар үүсэхгүй.

Олон улсын олимпиадад орох 4-5 хүүхэд болон багш нарын зардлыг улсын төсвөөс хариуцахад тухайн зохион байгуулах улс орноос хамааран зардлын хувьд ялгавартай боловч нэг жилд дунджаар 574.2 сая төгрөг шаардагдах магадлалтай.

№	Нэгж	Ажил үйлчилгээ	Тохиолдлын тоо	Олимпиадад оролцох давтамж	Томилолтын зардал	Нийт зардал /төг/
1	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага	Хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх сонгон хичээл, дугуйлан хичээллүүлэх, төрөлжсөн хичээлийн улсын олимпиад зохион байгуулах, олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн шинжлэх ухааны олимпиадад ерөнхий боловсролын сургуулийн суралцагч гадаад улс оронд оролцохтой холбогдох зардлын тодорхой хувийг улсын төсвөөс санхүүжүүлнэ	60	1	9,570,000	574,200,000
<b>НИЙТ</b>			<b>60</b>	<b>1</b>		<b>574,200,000</b>

**ЗАРДЛЫН АНГИЛАЛ**

**БОЛОВСРОЛ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА**

**НИЙТ ЗАРДАЛ**

<b>МАТЕРИАЛЛАГ ЗАРДАЛ</b>	+	<b>10,138,500,000</b>	=	<b>10,138,500,000</b>
---------------------------	---	-----------------------	---	-----------------------

=

=

=

<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	+	<b>10,138,500,000</b>	=	<b>10,138,500,000</b>
--------------------	---	-----------------------	---	-----------------------

**ЗАРДЛЫН АНГИЛАЛ**

**БОЛОВСРОЛ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА**

**НИЙТ ЗАРДАЛ**

<b>МАТЕРИАЛЛАГ ЗАРДАЛ</b>	+	<b>17,644,519,969</b>	=	<b>17,644,519,969</b>
---------------------------	---	-----------------------	---	-----------------------

=

=

=

<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	+	<b>17,644,519,969</b>	=	<b>17,644,519,969</b>
--------------------	---	-----------------------	---	-----------------------

**ЗАРДЛЫН АНГИЛАЛ**

**БОЛОВСРОЛ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА**

**НИЙТ ЗАРДАЛ**

<b>МАТЕРИАЛЛАГ ЗАРДАЛ</b>	+	<b>574,200,000</b>	=	<b>574,200,000</b>
=		=		=
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>		<b>574,200,000</b>	=	<b>574,200,000</b>

Төрийн байгууллагад нэмж үүсэх нийт зардлыг дараах байдлаар тооцоолон гаргалаа.

#### Зардлын нэгтгэл

<b>ЗАРДЛЫН АНГИЛАЛ</b>	<b>БОЛОВСРОЛ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА</b>	<b>НИЙТ ЗАРДАЛ</b>
<b>МАТЕРИАЛЛАГ ЗАРДАЛ</b>	<b>10,138,500,000</b>	<b>10,138,500,000</b>
	+	+
<b>МАТЕРИАЛЛАГ ЗАРДАЛ</b>	<b>17,644,519,969</b>	<b>17,644,519,969</b>
	+	+
<b>МАТЕРИАЛЛАГ ЗАРДАЛ</b>	<b>574,200,000</b>	<b>574,200,000</b>
		=
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>28,357,219,969</b>	<b>28,357,219,969</b>

#### ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ НИЙТ ЗАРДАЛ

Хуулийг төслийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагад үүсэх зардлыг дараах байдлаар тооцоолон гаргалаа.

#### Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах

Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад харьяалагддаг 6 байгууллагын нэгтгэн Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болгон бүтэц зохион байгуулалтыг өөрчлөхөд одоогийн ажиллаж буй орон тоо, батлагдсан төсөвт багтаан ажиллуулах боломжтой бөгөөд бүтэц, зохион байгуулалтыг хийхдээ ажлын байрны тодорхойлолт, чиг үүргийг нэг бүрчлэн илүү нарийвчлан тооцох шаардлагатай.

Харин хуулийн төсөлд туссан боловсрол сургалтын байгууллагад үүсэх зардлыг дараа жилийн төсвийн төсөлд тусгаж зардлыг шийдвэрлүүлэх шаардлагатай.

## 2. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах хуулийн этгээдийн зардлыг тооцох ажлыг дараах үе шаттайгаар зохион байгууллаа.

## Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тодорхойлсон байдал

Боловсролын ерөнхий хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Үүргийг хэрэгжүүлэх нэгж	Үүргийн мэдээллийн агуулга
<b>Боловсролын тусгай зөвшөөрөл олгох</b>		
Боловсролын сургалтын байгууллага нь тусгай зөвшөөрлийн үндсэн дээр сургуулийн өмнөх, бага, дунд, мэргэжлийн болон дээд боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд байна.	Хүсэлт гаргасан аж ахуй нэгж байгууллага	Тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлт, холбогдох материалыг эрх бүхий байгууллагад хүргүүлэх
Боловсролын сургалтын байгууллага шинэ мэргэжлээр сургалт явуулах, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл авахдаа Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан баримт бичгээс гадна энэ хуулийн 21.1.3-21.1.10-т заасан баримт бичиг, шинээр эрхлэх сургалтын үндэслэл, танилцуулга, тооцоог сургалтын үйл ажиллагаа эхлэхээс таваас доошгүй сарын өмнө тусгай зөвшөөрөл олгох байгууллагад цахимаар ирүүлнэ.		Шаардлагыг хангасан тохиолдолд тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах, холбогдох материалын хамт эрх бүхий байгууллагад хүргүүлэх
Эрх бүхий байгууллага нь төрийн захиргааны болон боловсролын байгууллага, холбогдох мэргэжлийн байгууллагын төлөөлөл бүхий шинжээчийн баг томилж, баримт бичигт магадлан шинжилгээ хийлгэж, барилга, техник тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнд үзлэг хийнэ. Магадлан шинжилгээ, үзлэг хийхтэй холбогдсон зардлыг хүсэлт гаргагч хариуцна.		Томилогдсон шинжээчийн багт магадлан шинжилгээ хийлгэх
<b>Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах</b>		
Боловсролын сургалтын байгууллага нь тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас гурваас доошгүй сарын өмнө хугацаа сунгуулах хүсэлтийг тусгай зөвшөөрөл олгосон эрх бүхий этгээдэд цахимаар гаргана.	Хүсэлт гаргасан аж ахуй нэгж байгууллага	Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах өргөдөл гаргах
Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд нь тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах шийдвэр гаргахаас өмнө тусгай зөвшөөрлийн шаардлага хангаж байгаа эсэхэд магадлан шалгалт хийнэ.		Магадлан шалгалт хийлгэх

## Хуулийн этгээдийн зардлыг тодорхойлсон байдал

Хуулийн этгээдийн зардлыг тооцоход өмнөх жилүүдэд өөрчлөлт орсон байгууллагын тоон үзүүлэлтийг тохиолдлын тоо, давтамжаар тооцсоныг хүснэгтээр харуулав.

Байгууллага	2016	2017	2018	2019	Тохиолдлын тоо
Цэцэрлэг	38	38	8	(17)	17
Сургууль	1	13	1	11	7
Их, дээд сургууль	(4)	1	(2)	(2)	(2)
Дүн	35	52	7	(8)	22

Хуулийн этгээдийн зардлыг тооцоход тухайн ажил үйлчилгээнд зарцуулах хугацааг тогтооходоо тусгай зөвшөөрөл авах, сунгах үйл ажиллагаанд зарцуулах хугацааг тусгав.

Агуулга	Үүргийн мэдээллийн агуулга	Хугацаа
---------	----------------------------	---------

Боловсролын тусгай зөвшөөрөл олгох	Тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлт, холбогдох материалыг эрх бүхий байгууллагад хүргүүлэх	30
	Шаардлагыг хангасан тохиолдолд тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах, холбогдох материалын хамт эрх бүхий байгууллагад хүргүүлэх	120
	Томилогдсон шинжээчийн багт магадлан шинжилгээ хийлгэх	1920
Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах	Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах өргөдөл гаргах	30
	Магадлан шалгалт хийлгэх	960

**Error! Not a valid link.**Хуулийн төслийн хүрээнд аж ахуй нэгж байгууллага нь тусгай зөвшөөрөл авах үйл ажиллагаанд ойролцоогоор 225,630 төгрөг, тусгай зөвшөөрөл сунгах үйл ажиллагаанд ойролцоогоор 107,910 төгрөгийн зардал гарахаар тооцооллыг боловсруулав.

Агуулга	Үүргийн мэдээллийн агуулга	Зарцуулах хугацаа /мин/	Ажлын хөлс	Зардал /төг/
Боловсролын тусгай зөвшөөрөл олгох	Тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлт, холбогдох материалыг эрх бүхий байгууллагад хүргүүлэх	30	109	3,270
	Шаардлагыг хангасан тохиолдолд тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах, холбогдох материалын хамт эрх бүхий байгууллагад хүргүүлэх	120	109	13,080
	Томилогдсон шинжээчийн багт магадлан шинжилгээ хийлгэх	1920	109	209,280
Дүн		2070		225,630
Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах	Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах өргөдөл гаргах	30	109	3,270
	Магадлан шалгалт хийлгэх	960	109	104,640
Дүн		990		107,910

Хуулийн төслийг хэрэгжүүлэхэд тусгай зөвшөөрлийг авахад жилдээ дунджаар 22 байгууллага авахаар тохиолдлын тоог тооцоход хуулийн этгээдэд нийт 4,963,860 төгрөг, тусгай зөвшөөрөл сунгуулахад жилдээ дунджаар 40 байгууллага сунгуулахаар тохиолдлын тоог тооцоход хуулийн этгээдэд нийт 4,257,540 төгрөг нийт хуулийн этгээдээс жилдээ дунджаар 9,221,400 төгрөгийн зардал гарах тооцоололтой байна.

Агуулга	Үүргийн мэдээллийн агуулга	Тохиолдлын тоо	Зардал /төг/	Зардал /төг/
Боловсролын тусгай	Тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлт, холбогдох материалыг эрх бүхий байгууллагад хүргүүлэх	22	3,270	71,940

зөвшөөрөл олгох	Шаардлагыг хангасан тохиолдолд тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах, холбогдох материалын хамт эрх бүхий байгууллагад хүргүүлэх	22	13,080	287,760
	Томилогдсон шинжээчийн багт магадлан шинжилгээ хийлгэх	22	209,280	4,604,160
Дүн		22	225,630	<b>4,963,860</b>
Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах	Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах өргөдөл гаргах	22	3,270	71,940
	Магадлан шалгалт хийлгэх	40	104,640	4,185,600
Дүн		40	107,910	<b>4,257,540</b>
Бүгд дүн		62		<b>9,221,400</b>

### Хуулийн этгээдийн нэмэлт зардал

Захиргааны зардал	Тоон үзүүлэлт	Бусад зардал	Нэмэлт зардал
Тусгай зөвшөөрөл авахад шаардагдах бичиг хэргийн зардал	22	20,000	440,000
Тусгай зөвшөөрөл сунгуулахад шаардагдах бичиг хэргийн зардал	40	20,000	800,000
Дүн			1,240,000

### ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ НИЙТ ЗАРДЛЫН ТООЦОО

<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>9,221,400</b>
+	+
<b>НЭМЭЛТ ЗАРДАЛ</b>	<b>1,240,000</b>
=	=
<b>ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДАЛ</b>	<b>10,461,400</b>

### 3. ИРГЭНД ҮҮСЭХ НИЙТ ЗАРДЛЫН ТООЦОО

Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 53 дугаар тогтоолын дагуу 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн үдийн цай хөтөлбөрийг үдийн хоол хөтөлбөрт шилжүүлэх шийдвэр гарсан. 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс ҮДИЙН ХООЛ болгон хэрэгжүүлж суралцагчийн эцэг, эх, асран хамгаалагчаас тодорхой хувийг хариуцахаар туссан. Эцэг, эх асран хамгаалагчийн хувьд жилдээ 9 удаа хоолны зардлыг төлөхөд нийт жилдээ дунджаар 0-100 минутын хугацааг зарцуулахаар байна.

Иргэний гүйцэтгэх үүрэг

Иргэний гүйцэтгэх үүрэг	Зарцуулах хугацаа /минут/	Давтамж /сар/	Зарцуулах хугацаа /минут/
Цэцэрлэгийн хоолны зардлыг төлөх	10	9	90

### Иргэний зардал

Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль 14.2.8. хүүхдийнхээ хоолны зардлын тодорхой хувийг хариуцахаар заасан байсан боловч одоогоор 100 хувь улсын төсвөөс зарцуулж байна. Иргэнд үүсэх зардлын тооцоог дараах хүснэгтээр харуулав.

Боловсролын ерөнхий хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Үүргийн мэдээллийн агуулга	Давтамж /хоног/	Зардал /нэг өдрийн эцэг эхийн хариуцах хүүхдийн хоолны зардал/	Нийт зардлын дүн /нэг жилийн эцэг, эхийн жилийн хариуцах хоолны зардал/	Тохиолдлын тоо /хүүхдийн тоо/	Нийт иргэдэд үүсэх зардал
төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд улс, орон нутгийн төсөв, туслах үйл ажиллагааны орлого болон эцэг, эх, асран хамгаалагчаас хариуцах хуульд заасан зардал	Эцэг, эх цэцэрлэгийн хүүхдийн хоолны тодорхой хувийг хариуцах	189	1750	330750	210000	69,457,500,000
42.2.8.энэ хуулийн 40.5.1-д заасан зардлын тодорхой хувийг хариуцах	Эцэг, эх сургуулийн үдийн хоолны тодорхой хувийг хариуцах	165	600	99000	330000	32,670,000,000

2021 онд сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламжийн зардалд 24.7 тэрбум төгрөгийг улсын төсөвт батлагдсан бөгөөд Боловсролын зээлийн сангаар дамжин олгогдож байна.

Оюутны хөгжлийн зээлээр суралцаж байгаад Монгол Улсад эрэлттэй мэргэжлийн жагсаалтаас хасагдсан оюутнууд төлбөрөө хариуцна

Утга	Оюутны тоо	Нэг иргэний зардал	Иргэдээс гарах зардал
------	------------	--------------------	-----------------------



Зээлд хамрагдаагүй	1693	1,500,000	<b>2,539,500,000</b>
-----------------------	------	-----------	----------------------

Олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн шинжлэх ухааны олимпиадад ерөнхий боловсролын сургуулийн суралцагч гадаад улс оронд оролцохтой холбогдох зардалд нийт 6 төрлийн олимпиадад жилд нэг удаа оролцоход 4-5 хүүхэд болон багш нар оролцоно. Эцэг, эхчүүд, багш нар хүүхдээ олимпиадад бэлтгэх, ирж очиход шаардлагатай хувийн бэлтгэлийг хангахад нэг удаа дунджаар 980.0 мянган төгрөгийн зардал гарахаар тооцсон. Жилдээ дунджаар 60 хүүхдээр зардлын тооцсон.

Утга	Хүүхдийн тоо	Дундаж зардал	Нийт зардал
Олон улсын олимпиадад оролцох	60	980,000	58,800,000

#### ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

<b>ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ</b>	<b>102,127,500,000</b>
+	+
<b>ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ</b>	<b>2,539,500,000</b>
+	+
<b>ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ</b>	<b>58,800,000</b>
=	=
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>104,725,800,000</b>

#### 1. ИРГЭНД ҮҮСЭХ НИЙТ ЗАРДЛЫН ТООЦОО

Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 53 дугаар тогтоолын дагуу 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн үдийн цай хөтөлбөрийг үдийн хоол хөтөлбөрт шилжүүлэх шийдвэр гарсан. 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс ҮДИЙН ХООЛ болгон хэрэгжүүлж суралцагчийн эцэг, эх, асран хамгаалагчаас тодорхой хувийг хариуцахаар туссан. Эцэг, эх асран хамгаалагчийн хувьд жилдээ 9 удаа хоолны зардлыг төлөхөд нийт жилдээ дунджаар 0-100 минутын хугацааг зарцуулахаар байна.

Иргэний гүйцэтгэх үүрэг

Иргэний гүйцэтгэх үүрэг	Зарцуулах хугацаа /минут/	Давтамж /сар/	Зарцуулах хугацаа /минут/
Цэцэрлэгийн хоолны зардлыг төлөх	10	9	90
Сургуулийн үдийн хоолны зардлыг төлөх	10	10	100

## Иргэний зардал

Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль 14.2.8. хүүхдийнхээ хоолны зардлын тодорхой хувийг хариуцахаар заасан байсан боловч одоогоор 100 хувь улсын төсвөөс зарцуулж байна. Иргэнд үүсэх зардлын тооцоог дараах хүснэгтээр харуулав.

Боловсролын ерөнхий хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Үүргийн мэдээллийн агуулга	Давтамж /хоног/	Зардал /нэг өдрийн эцэг эхийн хариуцах хүүхдийн хоолны зардал/	Нийт зардлын дүн /нэг жилийн эцэг, эхийн жилийн хариуцах хоолны зардал/	Тохиолдлын тоо /хүүхдийн тоо/	Нийт иргэдэд үүсэх зардал
төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд улс, орон нутгийн төсөв, туслах үйл ажиллагааны орлого болон эцэг, эх, асран хамгаалагчаас хариуцах хуульд заасан зардал	Эцэг, эх цэцэрлэгийн хүүхдийн хоолны тодорхой хувийг хариуцах	189	1750	330750	210000	69,457,500,000
42.2.8.энэ хуулийн 40.5.1-д заасан зардлын тодорхой хувийг хариуцах	Эцэг, эх сургуулийн үдийн хоолны тодорхой хувийг хариуцах	165	600	99000	330000	32,670,000,000

2021 онд сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламжийн зардалд 24.7 тэрбум төгрөгийг улсын төсөвт батлагдсан бөгөөд Боловсролын зээлийн сангаар дамжин олгогдож байна.

Оюутны хөгжлийн зээлээр суралцаж байгаад Монгол Улсад эрэлттэй мэргэжлийн жагсаалтаас хасагдсан оюутнууд төлбөрөө хариуцна

Утга	Оюутны тоо	Нэг иргэний зардал	Иргэдээс гарах зардал
Зээлд хамрагдаагүй	1693	1,500,000	<b>2,539,500,000</b>

Олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн шинжлэх ухааны олимпиадад ерөнхий боловсролын сургуулийн суралцагч гадаад улс оронд оролцохтой холбогдох зардалд нийт 6 төрлийн олимпиадад жилд нэг удаа оролцоход 4-5 хүүхэд болон багш нар оролцоно. Эцэг, эхчүүд, багш нар хүүхдээ олимпиадад бэлтгэх, ирж очиход шаардлагатай хувийн бэлтгэлийг хангахад нэг удаа дунджаар 980.0 мянган төгрөгийн зардал гарахаар тооцсон. Жилдээ дунджаар 60 хүүхдээр зардлын тооцсон.

Утга	Хүүхдийн тоо	Дундаж зардал	Нийт зардал
Олон улсын олимпиадад оролцох	60	980,000	58,800,000

#### **ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО**

<b>ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ</b>	<b>102,127,500,000</b>
+	+
<b>ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ</b>	<b>2,539,500,000</b>
	+
<b>ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ</b>	<b>58,800,000</b>
	=
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>104,725,800,000</b>